



ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН  
2024 ОН



АГУУЛГА

НЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	2
1.1. Судалгааны зорилго, зорилт .....	2
1.2. Судалгааны зарчим, арга .....	2
1.3. Судалгааны хамрах хүрээ .....	2
1.4. Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт .....	2
1.5. Шударга байдлын шалгуур, тооцоолол .....	3
1.5.1 Үнэлгээний утга .....	3
1.5.2 Шалгуур .....	3
1.5.3 Үнэлгээг тооцох арга .....	3
ХОЁР. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	5
2.1. Сурагч .....	5
2.2. Эцэг, эх.....	6
2.3. Багш, албан хаагч.....	7
ГУРАВ. СУДАЛГААНЫ ДҮН .....	8
3.1. Хүүхдийн шударга байдлын түвшин .....	8
3.2. Хүүхдийн шударга байдалд нөлөөлж буй хүчин зүйл.....	11
3.3. Эцэг, эхчүүдийн судалгааны дүн .....	17
3.4. Багш, албан хаагчдын судалгааны дүн .....	19
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ .....	21
ТАВ. ЗӨВЛӨМЖ .....	24
ЗУРГАА. ХАВСРАЛТ .....	25

## НЭГ. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 1.1. Судалгааны зорилго, зорилт

#### **Зорилго:**

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын шударга байдлын түвшин, түүний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, төлөвшил, мөн хууль сахих болон авлигыг үл тэвчих чадвар, хандлага ямар түвшинд байгааг тодорхойлох, цаашид хүүхдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтооход энэхүү судалгааны зорилго оршино.

#### **Зорилт:**

1. Хүүхдийн шударга ёсны талаарх ойлголт, мэдээлэл, хандлагыг тодорхойлох;
2. Хүүхдийн шударга байдлын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох;
3. Хүүхдийн шударга бус байдалд хандах хандлагыг тодорхойлох;
4. Хүүхдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тодорхойлох;
5. Эцэг эх, багш, асран хамгаалагчдын шударга ёсны талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох

### 1.2. Судалгааны зарчим, арга

Судалгаа нь аливаа улс төрийн байгууллага, албан тушаалтны бодлого, нөлөөллөөс ангид бие даасан, хараат бус байх, шинжлэх ухааны арга зүйг баримталсан байх, үндэслэл бүхий байх, мэдээллийн эх үүсвэр тодорхой байх, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмыг удирдлага болгон явууллаа.

Монгол Улсын АТГ-ын даргын 2020 оны 3 сарын 12-ны өдрийн А/23 дугаар тушаалаар Монгол Улсын онцлогт нийцсэн Хүүхдийн шударга байдлын судалгааны арга, аргачлал, тус судалгааг зохион байгуулах ажлын удирдамж, судалгааны санал асуулгын загвар төслийг тус тус баталсан бөгөөд тус аргачлалд дурдсанаар судалгааг санал асуулгын аргаар явуулан үр дүнг нь тооцоолсон.

### 1.3. Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд улсын хэмжээний төрийн болон хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын 10-12 дугаар ангийн сурагч, тэдгээрийн эцэг эх, багш, сургуулийн албан хаагч нарыг хамруулсан.

### 1.4. Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт

Санал асуулгын судалгааг цахим хэлбэрээр “SurveyMonkey” судалгааны программыг ашиглан, 21 аймаг болон нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн **1)** 10-12 дугаар ангийн сурагчид, **2)** багш, албан хаагч, **3)** эцэг, эх гэсэн 3 бүлгээс судалгаанд оролцогчийг санамсаргүй байдлаар сонгон авсан бөгөөд санал асуулгын судалгаагаар цугларсан мэдээллийг SPSS программ ашиглан боловсруулж, үр дүнд үндэслэн судалгааны тайланг боловсруулав.

## 1.5. Шударга байдлын шалгуур, тооцоолол

### 1.5.1 Үнэлгээний утга

Хүүхдийн шударга байдлын үнэлгээг 1-5 хүртэлх оноогоор гаргах бөгөөд үнэлгээ 5 руу дөхөх тусам хүүхдийн шударга байдал өндөр байгааг илэрхийлнэ.



### 1.5.2 Шалгуур

Хүүхдийн шударга байдлын түвшнийг хүүхдийн ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт, зөв төлөвшилтийн дэд үзүүлэлт, дүрэм, журам, хууль сахиx байдлын дэд үзүүлэлт болон авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтээр тооцно.

#### Хүснэгт 1. Шударга байдлын шалгуур

Шударга байдлын шалгуур	Тодорхойлолт
ХҮҮХДИЙН ЁС ЗҮЙ, ЁС СУРТАХУУНЫ ДЭД ҮЗҮҮЛЭЛТ	Хүүхдийн ёс зүй, ёс суртахууныг насны онцлогт тохирсон асуултаар тогтоох дэд үзүүлэлт ба уг дэд үзүүлэлт нь хүүхдийн ёс суртахууны хэм хэмжээг илэрхийлнэ.
ХҮҮХДИЙН ЗӨВ ТӨЛӨВШИЛТИЙН ДЭД ҮЗҮҮЛЭЛТ	Хүүхдийн зөв хүмүүжлийн төлөвшилтийг насны онцлогт тохирсон асуултаар тогтоох дэд үзүүлэлт ба хүүхэд зөв бурууг ялгаж буйг илэрхийлнэ.
ХҮҮХДИЙН ДҮРЭМ, ЖУРАМ, ХУУЛЬ САХИХ БАЙДЛЫН ДЭД ҮЗҮҮЛЭЛТ	Хүүхдийн хууль тогтоомж сахин биелүүлэх байдлыг насны онцлогт тохирсон асуултаар тогтоох дэд үзүүлэлт ба хэрхэн хүүхэд өөрийгөө хянаж нийгмийн тогтсон эрх зүйн хэм хэмжээг сахиж буйг илэрхийлнэ.
ХҮҮХДИЙН АВЛИГЫГ ҮЛ ТЭВЧИХ ДЭД ҮЗҮҮЛЭЛТ	Хүүхдийн насны онцлогт тохирсон асуултаар авлигын тохиолдлыг тэвчих байдлыг тогтоох дэд үзүүлэлт ба хүүхдийн авлигыг үл тэвчих чадварыг илэрхийлнэ.

### 1.5.3 Үнэлгээг тооцох арга

Хүүхдийн шударга байдлын түвшнийг тооцохдоо асуулгын 12 асуултыг дэд үзүүлэлтийн түвшнийг танин мэдэхүйн, нөлөөллийн, зан үйлийн байдлыг тогтооход чиглэснээр нь ангилан, тухайн асуулт судалгааны асуултад тухайн хүүхэд санал нийлж буй эсэхийг асууж, хариулт бүрийг 1-5 хүртэлх оноогоор үнэлнэ.

Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзэх ба хүүхдийн шударга байдлын түвшнийг дараах томъёогоор тооцон гаргана:

**Хүүхдийн шударга байдлын түвшнийг тооцон гаргах томьёо (1-7, 9-10, 12 дугаар асуултыг тооцох):**

$$\bar{x} = \frac{A_1 \cdot 5 + A_2 \cdot 4 + A_3 \cdot 3 + A_4 \cdot 2 + A_5 \cdot 1}{A_1 + A_2 + A_3 + A_4 + A_5}$$

$\bar{x}$  – үнэлгээ

$A_1$  – санал огт нийлэхгүй байна гэж хариулсан сурагчдын тоо

$A_2$  – санал нийлэхгүй байна гэж хариулсан сурагчдын тоо

$A_3$  – эргэлзэж байна гэж хариулсан сурагчдын тоо

$A_4$  – санал нийлж байна гэж хариулсан сурагчдын тоо

$A_5$  – санал бүрэн нийлж байна гэж хариулсан сурагчдын тоо

**Хүүхдийн шударга байдлын түвшнийг тооцон гаргах томьёо (8 ба 11 дүгээр асуултыг тооцох):**

$$\bar{x} = \frac{A_1 \cdot 1 + A_2 \cdot 2 + A_3 \cdot 3 + A_4 \cdot 4 + A_5 \cdot 5}{A_1 + A_2 + A_3 + A_4 + A_5}$$

$\bar{x}$  – үнэлгээ

$A_1$  – санал огт нийлэхгүй байна гэж хариулсан сурагчдын тоо

$A_2$  – санал нийлэхгүй байна гэж хариулсан сурагчдын тоо

$A_3$  – эргэлзэж байна гэж хариулсан сурагчдын тоо

$A_4$  – санал нийлж байна гэж хариулсан сурагчдын тоо

$A_5$  – санал бүрэн нийлж байна гэж хариулсан сурагчдын тоо.

**Хүүхдийн шударга байдлын түвшний ерөнхий дунджийг арифметикийн дунджийг ашиглана:**

$$\bar{x} = \frac{\sum X_i \cdot f_i}{\sum f_i}$$

$\bar{x}$  – хүүхдийн шударга байдлын түвшний үнэлгээний дундаж

$x_i$  –  $i$  асуултын үнэлгээний дундаж оноо

$f_i$  –  $i$  дугаар асуултад хариулсан хүүхдийн тоо


## ХОЁР. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 2.1. Сурагч

Монгол улсын 21 аймаг, нийслэлийн төрийн болон хувийн өмчийн сургуулийн 10-12 дугаар ангийн нийт 6670 сурагчдын төлөөлөл хамрагдсан.


Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 41.35 хувь нь эрэгтэй, 58.65 хувь нь эмэгтэй байна. Сурагчдын нас, хүйсийн байдлаас харахад эмэгтэй сурагчид судалгаанд идэвхтэй хамрагдсан байна.

Зураг 1. Сурагчдын нас, хүйс



Судалгаанд оролцсон суралцагчдын 28.9 хувь нь 12 дугаар ангид, 34.8 хувь нь 11 дүгээр ангид, 36.3 хувь нь 10 дугаар ангид тус тус суралцаж байна.

Зураг 2. Сурагчдын анги, хүйс




## 2.2. Эцэг, эх

Улсын хэмжээнд төрийн өмчийн болон хувийн хэвшлийн ЕБС-уудын 10-12 дугаар ангийн сурагчдын нийт 1293 эцэг, эх судалгаанд хамрагдсан.


Судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн 83 хувь нь эмэгтэй, 17 хувь нь эрэгтэй байна. Эцэг эхчүүдийн 56 хувь нь 35-44 настай, 24.7 хувь нь 45-54 настай, 17 хувь нь 34 хүртэлх, 3.1 хувь нь 55-аас дээш настай байна.

Зураг 3. Эцэг эхчүүдийн нас, хүйс



Боловсролын түвшнээр нь авч үзвэл дээд болон бүрэн дунд боловсролтой эцэг эхчүүдийн тоо зонхилж байна. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд төрийн байгууллагад ажилладаг эцэг эхчүүд судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн гуравны нэгийг эзэлж байхад хувийн хэвшилд ажиллаж буй эцэг эхчүүд 28.3 хувийг эзэлж байна.


Зураг 4. Эцэг эхчүүдийн боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлт



2.3. Багш, албан хаагч


Судалгаанд нийт 789 багш, ажилтан хамрагдсанаас 19.9 хувь нь эрэгтэй, 80.1 хувь нь эмэгтэй багш ажилчид байна.

Зураг 5. Багш, албан хаагчдын насны бүлэг, хүйс



Судалгаанд хамрагдсан багш, албан хаагчдын 24.7 хувь нь 1-5 жил, 26.6 хувь нь 5-10 жил, 17 хувь нь 11-15 жил, 15.5 хувь нь 15-20 жил, 16.2 хувь нь 20-оос дээш жил боловсролын салбарт ажилласан байна.

Зураг 6. Багш, албан хаагчдын ажилласан жил, албан тушаал






## ГУРАВ. СУДАЛГААНЫ ДҮН

### 3.1. Хүүхдийн шударга байдлын түвшин


Хүүхдийн шударга байдлын түвшин 2024 онд 4.05 оноотой гарч өмнөх буюу 2023 оноос 0.08 оноогоор өссөн дүнтэй байна. Судалгаанаас үзвэл хүүхдийн шударга байдлын үндсэн үзүүлэлтэд томоохон өөрчлөлт гараагүй байгаа ч эерэг тал руу тэмүүлэх хандлага ажиглагдаж байна.

Зураг 7. Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор




Хүүхдийн шударга байдлын түвшний үзүүлэлтийг оршин суугаа нутаг дэвсгэрээр харьцуулан үзвэл Дундговь аймгийн хүүхдийн шударга байдал 4.33 оноотой гарч хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Харин Орхон аймгийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин 3.84 буюу хамгийн бага дүнтэй гарчээ. Нийт судалгаанд хамрагдсан 21 аймгаас 9 аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин улсын дунджаас өндөр дүнтэй гарч, Баянхонгор болон Булган аймгийн хүүхдийн шударга байдлыг түвшин улсын дундажтай тэнцүү үнэлэгдэв. 10 аймгийн үзүүлэлт улсын дунджаас доогуур дүнтэй гарчээ. Өмнөх жилийн судалгааны үзүүлэлтээр Орхон аймаг хүүхдийн шударга байдлын түвшнээр мөн адил хамгийн бага үнэлэгдэж байсан ба тус үзүүлэлт давтагдлаа. Хамгийн өндрөөр үнэлэгдсэн Дундговь аймаг болон хамгийн багаар үнэлэгдсэн Орхон аймгуудын хүүхдийн шударга байдлын түвшний зөрүү 0.49 байгаа нь анхаарал татахуйц үзүүлэлт байна.

Зураг 8. Хүүхдийн шударга байдлын түвшин 2024 он, аймгаар




Хүүхдийн шударга байдлын түвшинг Нийслэлийн дүүргүүдээр харьцуулан үзвэл Сонгинохайрхан дүүрэг 4.25 буюу улсын дунджаас 0.2 оноогоор өндөр үзүүлэлттэй гарсан байна. Харин Багахангай дүүргийн хүүхдийн шударга байдлын түвшин хамгийн бага буюу 3.80 оноотой гарч, хоорондоо 0.45 онооны зөрүүтэй байна. Сонгинохайрхан, Багануур дүүргүүдийн хүүхдийн шударга байдлын түвшин улсын дунджаас өндөр гарсан бол Чингэлтэй дүүргийн хүүхдийн шударга байдлын түвшин улсын дундажтай тэнцүү, Налайх, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Баянгол, Багахангай дүүргүүдийн хүүхдийн шударга байдлын түвшин улсын дунджаас доогуур үнэлгээтэй байна.

Зураг 9. Хүүхдийн шударга байдлын түвшин 2024 он, дүүргээр




Өмнөх онуудын судалгааны үр дүнгээс харахад жил бүр эмэгтэй хүүхдүүдийн шударга байдлын түвшин эрэгтэй хүүхдүүдийнхээс өндөр гарч байсан бол 2024 оны хувьд ч мөн адил тус тохиолдол давтагдаж байна. Энэ оны судалгааны үр дүнгээр эмэгтэй хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.14 оноотой байгаа бол эрэгтэй хүүхдийнх 3.90 оноотой гарсан нь өмнөх онтой харьцуулбал өсөлттэй үзүүлэлт байна.

Зураг 10. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүйсээр



Төрийн өмчийн сургуулиудын хүүхдүүдийн шударга байдлын түвшин 2024 онд 3.78 оноотой гарсан бол хувийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.08 буюу 0.3 оноогоор дээгүүр үзүүлэлттэй байна. Өмнөх онуудад төрийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшний үнэлгээ хувийн хэвшлийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин үнэлгээнээс их гарч байсан бол, 2023 болон 2024 онд төрийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн үнэлгээ хувийн өмчийн сургуулийн хүүхдийн үнэлгээнээс бага гарсан байна. Энэ оны хувьд төрийн болон хувийн хэвшлийн сургууль хоорондын хүүхдийн шударга байдлын үнэлгээний зөрүү хамгийн өндөр гарч буй жилүүдийн нэг болж байна.

Зураг 11. Хүүхдийн шударга байдлын түвшин, өмчийн хэлбэрээр



Хүүхдийн шударга байдлын түвшнийг тэдний насны онцлогт тохируулан хүүхэд зөв бурууг ялгаж буй эсэхийг илэрхийлэх, нийгмийн тогтсон хэм хэмжээ, зарчмыг хэрхэн сахиж буй байдлыг үнэлэх, бурууг үл тэвчиж буй чадварыг тогтооход чиглэсэн, дор дурдсан 12 асуултад хэрхэн хариулснаар үнэлэн шинжилж, дүгнэх замаар судлан тогтоосон болно.


Судалгааны мэдээллээс дэд үзүүлэлт бүрийн танин мэдэхүйн, нөлөөллийн, зан үйлийн түвшний үзүүлэлт дараах байдлаар харагдаж буй нь дор дурдсан дүгнэлтэд хүргэж байна.

Хүүхдийн ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт




Тус үзүүлэлт нь хүүхдийн ёс суртахууны хэм хэмжээг илэрхийлэх бөгөөд судалгааны дүнгээс хүүхдийн ёс суртахууны талаарх танин мэдэхүй, нөлөөллийн түвшин зан үйлийн түвшнээс доогуур байгаа нь хүүхдэд чиглэсэн, ёс зүй, ёс суртахууны талаарх танин мэдэхүйн мэдлэг, мэдээлэл шаардлагатай байгааг харуулж байна.

Хүүхдийн зөв шударга төлөвшилтийн дэд үзүүлэлт



Тус үзүүлэлт хүүхэд зөв бурууг ялгаж буйг илэрхийлэх бөгөөд тус үзүүлэлтийн тухайд зан үйлийн түвшин танин мэдэхүйн болон нөлөөллийн түвшнээс доогуур байгаа нь хүүхдэд багаас нь зөв шударга байдлын дадал суулгах шаардлагатайг харуулж байна.

Хүүхдийн дүрэм, журам, хууль сахиу байдлын дэд үзүүлэлт



Тус үзүүлэлт хүүхэд хэрхэн өөрийгөө хянаж, нийгмийн тогтсон эрх зүйн хэм хэмжээг сахиж буйг илэрхийлэх бөгөөд энэхүү үзүүлэлтийн нөлөөллийн болон зан үйлийн түвшин танин мэдэхүйн түвшнээс өндөр байгаа нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг хүүхдэд таниулах шаардлага буйг илэрхийлж байна.

Хүүхдийн авлигыг үл тэвчих дэд үзүүлэлт



Энэ үзүүлэлт хүүхдийн авлигыг үл тэвчих байдлын чадварыг илэрхийлэх ба тус үзүүлэлтийн нөлөөллийн түвшин танин мэдэхүйн болон зан үйлийн түвшнээс доогуур байгаа нь хүүхдэд авлигын шинжтэй үйлдлийн талаар авах арга хэмжээний талаарх ойлголт дутмаг байгааг илэрхийлж байна.

## 3.2. Хүүхдийн шударга байдалд нөлөөлж буй хүчин зүйл

Хүүхдийн шударга байдалд нөлөөлж буй хүчин зүйл, түүний ач холбогдлыг тодорхойлох зорилгоор хүүхдийн шударга байдалд хөндлөнгөөс нөлөөлж болох хүчин зүйлийг тодорхойлох асуултад хариулт авах, улмаар тухайн хүчин зүйл нь хүүхдийн

шударга байдлын түвшинд хэрхэн нөлөөлснийг аргачлалын дагуу 1-5 оноогоор үнэлэх замаар шинжлэн дүгнэв.


Судалгаагаар шударга байх талаар гэрийнхэнтэйгээ байнга ярилцдаг хүүхдийн шударга байдлын түвшин 3.99 оноотой байгаа бол заримдаа ярилцдаг хүүхдийнх 4.21 оноотой, хэзээ ч ярилцдаггүй хүүхдийнх 3.62 оноогоор үнэлэгдсэн байна. Иймд эцэг эх, асран хамгаалагч болон гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхэдтэйгээ шударга байх талаар их, бага хэмжээнд ярилцдаг байх нь хүүхдийн төлөвшилд чухал нөлөө үзүүлдэг гэж дүгнэж болохоор байна.

*Зураг 12. Шударга байх талаар гэрийнхэнтэйгээ ярилцах нь хүүхдийн шударга байдалд нөлөөлдөг эсэх*




Хүүхдийн шударга байдлын түвшинд эергээр нөлөөлөх нэг чухал хүчин зүйл бол тухайн хүүхдийг шударга хандсаных нь төлөө магтаж, сайшаадаг хүүхдийн шударга байдлын түвшин 3.96 оноотой, шударга байсан ч үл ойшоогддог хүүхдийн шударга байдлын түвшин 3.84 оноогоор үнэлэгджээ. Хүүхдийг шударга үйлдэл хийх, аливаа зүйлд шударга хандахад нь магтан сайшаах, урамшуулах нь хүүхдэд багаас нь аливаа зүйлд шударга, зөв байхыг төлөвшүүлэх эерэг нөлөөтэй гэж судалгааны мэдээллээс дүгнэж байна. Иймд гэр бүл, сургууль болон бусад орчинд хүүхдийн шударга байдлыг урамшуулахад анхаарал хандуулах, шаардлагатай арга хэмжээ авах хэрэгтэй юм.

*Зураг 13. Хүүхдийг шударга хандсаных нь төлөө магтах нь хүүхдийн шударга байдалд нөлөөлдөг эсэх*



Судалгаагаар шударга бус зүйл хийснийх нь төлөө гэр бүлийнхэн нь хэлж ойлгуулдаг хүүхдийн шударга байдлын түвшин 3.97 оноотой, зэмлэж шийтгэдэг бол 3.89 оноотой, гэр бүлийнхэн нь сонирхдоггүй бол 3.52 оноогоор үнэлэгджээ. Зарим тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдийг зэмлэж шийтгэхээс илүү учирлан хэлж, ойлгуулах нь илүү үр дүнтэй, эерэг нөлөөтэй байж болзошгүй.

Зураг 14. Хүүхдүүд шударга бус зүйл хийхэд эцэг, эхийн гаргадаг харуу үйлдэл хүүхдийн шударга байдалд нөлөөлдөг эсэх




Судалгаагаар шударга бус үйлдлийн талаар ангийнхан, найз нартайгаа ярилцдаг хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ 3.95 оноотой гарсан бол, ярилцдаггүй хүүхдүүдийн үнэлгээ 3.79 оноотой гарсан байна. Үүнээс харахад хүүхдийн хүмүүжил, төлөвшилд эцэг эх, асран хамгаалагчаас гадна үе тэнгийнхний нөлөөлөл чухал байр суурийг эзэлж байна.

Зураг 15. Хүүхдүүд шударга бус үйлдлийн талаар ангийнхан, найз нартайгаа ярилцах нь хүүхдийн шударга байдалд нөлөөлдөг эсэх




Хичээлийн хөтөлбөрт нь шударга ёсны талаар агуулгыг багтаасан, шударга ёсны талаар хичээлээрээ дамжуулж мэдлэг, ойлголт авдаг хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.11 буюу шударга ёсны талаар хичээл заалгадаггүй хүүхдүүдийн шударга байдлын түвшнээс даруй 0.22 оноогоор их байна.

Зураг 16. Шударга ёсны талаар хичээл заах нь хүүхдийн шударга байдалд нөлөөлдөг эсэх



Шударга бус зүйл хийсэн ойр дотнынхоо хүнд зэмлэж сануулна гэсэн хүүхдийн шударга байдлын түвшин 4.08 оноотой, өөрт хамаагүй бол ямар ч үйлдэл хийхгүй хүүхдийн шударга байдлын түвшин 3.75 оноотой үнэлэгдсэн бол өөрт ашигтай байвал шударга бус үйлдлийг дэмжинэ гэж хариулсан хүүхдийн шударга байдлын түвшин 3.39 оноотой үнэлэгджээ.

Зураг 17. Та шударга бус зүйл хийсэн дотнынхоо хүнд яаж ханддаг вэ?




Зураг 18. Таны найз Танаас шударга бус үйлдэл хийхийг хүсдэг үү?



Хүүхдийг шударга бус үйлдэл хийхэд гэрийнхэн нь хэлж ойлгуулдаг хүүхдийн шударга байдлын түвшин 3.99, зэмлүүлж шийтгүүлдэг хүүхдийн шударга байдлын түвшин 3.94 оноотой үнэлэгдсэн байна. Шударга бус үйлдэл хийхэд нь ямар нэг хариу арга хэмжээ авдаггүй, тоодоггүй бол 3.64, яадаг ч үгүй


Зураг 19. Гэрийнхэн чинь шударга бус зүйл хийснийг чинь мэдвэл яадаг вэ?




Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 34 хувь нь интернэтээс, 25 хувь нь гэр бүлийн орчноос, 23 хувь нь сургуулийн орчноос, 7 хувь нь бусад эх сурвалжаас, 5 хувь нь телевиз, радиогоор, 2 хувь нь ном, хэвлэлээс шударга ёсны талаарх мэдээлэл олж авдаг гэж хариулжээ. Сургуулийн орчинд шударга ёсны талаар мэдээлэл авдаг хүүхдийн шударга байдлын түвшин хамгийн өндөр буюу 4.16 оноотой, удаагаар гэр бүлийнхээ орчноос шударга ёсны талаар мэдээлэл авдаг хүүхдийнх 4.11 оноотой, интернэт орчноос мэдээлэл авдаг хүүхдийнх 3.87 оноотой, ном, хэвлэлээс мэдээлэл авдаг бол 3.99, телевиз, радиогоос мэдээлэл авдаг бол 3.97 оноотой, бусад эх сурвалжаас мэдээлэл авдаг бол 3.92 оноотой харин найз нөхдөөсөө мэдээлэл авдаг бол 3.85 оноотой гарчээ.

Доорх дүнгээс харахад хүүхдийн шударга байдлын түвшин, шударга ёсны хандлага, төлөвшилд сургууль чухал эх сурвалж болохоос гадна тус орчинд мэдлэг, мэдээлэл авсан хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 20. Хүүхдүүдийн шударга ёсны талаарх мэдээлэл авдаг эх сурвалж, хувиар



Зураг 21. Хүүхдүүдийн шударга ёсны талаарх мэдээлэл авдаг эх сурвалж, түвшнээр



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн шударга ёсны талаарх ерөнхий ойлголт, хандлагыг тандах зорилгоор нээлттэй асуулт асуухад дараах байдлаар хариулжээ.

- **Ёс суртахуунтай холбоотой:** Шударга ёс бол үнэнч байдал, зөв үйлдэл, ёс суртахуунтай хамаатай.
  - **"Үнэнч байх"** – Үнэнч байдал, шударга ёс бол ёс суртахуунтай хамаатай гэдгийг онцолсон.
  - **"Ёс зүйтэй байх нь шударга ёсны үндэс"** - Шударга ёс ёс суртахууны гол хэсэг гэж үзсэн.
  - **"Өөрийн хийсэн буруу зүйлээ үнэн зөвөөр хүлээн зөвшөөрдөг байх"** - Үнэнч зан чанарыг шударга ёс гэж тодорхойлсон.
- **Тэгш байдлыг чухалчилсан:** Бүх хүнд тэгш хандах, хуулийн өмнө хүн бүр адил байх ёстой.
  - **"Тэгш хандах"** - Бүх хүнд ялгаваргүйгээр хандах хэрэгтэйг онцолсон.
  - **"Хүн бүр эрх тэгш байх ёстой"** - Нийгэмд бүх хүн адил боломж, эрхтэй байх ёстой.
  - **"Хуулийн өмнө хүн бүр адил эрхтэй байх"** - Тэгш байдал нь хуулийн хүрээнд хэрэгжих ёстой гэсэн санааг илэрхийлсэн.
- **Бусад ойлголтууд:** Хувь хүний үзэл бодол болон өвөрмөц тодорхойлолтууд.
  - **"Хүн бүр өөрийн гэсэн орон зайтай байх хэрэгтэй"** - Шударга ёсыг хувь хүний эрхтэй холбосон.
  - **"Бага ангид хоол өгдөг, том ангид өгдөггүй"** – Өдөр тутамд тохиолддог тэгш бус байдлыг жишээ болгон дурдсан.
  - **"Худал хэлэхгүй байх"** - Шударга ёсгүй байдал нь худал хуурмагтай хамаатай.
  - **"Өөрийн ашиг сонирхлыг дээгүүр тавих нь шударга бус"** - Нийтийн ашиг сонирхлыг хөндөж буй хувь хүний үйлдлийг шүүмжилсэн.
  - **"Үйлдэл болон үг хоорондоо зөрүүтэй байх"** - Үнэнч бус байдал нь шударга бус гэж онцолсон.




- **"Зарим хүмүүсийн боломж илүү байх"** - Зарим хүмүүст бусдаас илүү боломж олгогдсон байдаг нь шударга бус гэж үзжээ.
- **"Худал хэлж, мөнгөөр шударга ёсыг худалдаж авч болохгүй"** – Худал хуурмаг, авлига нийгэмд шударга ёсыг алдагдуулдаг.
- **"Ялгаварлан гадуурхах"** - Хүн бүрийг ижил байдлаар үнэлэхгүй байхыг шударга бус гэж үзжээ.
- **"Хүн болгон бүх зүйл дээр шударга бус хандвал хэзээ ч сайн үр дүнд хүрэхгүй"** - Тэгш бус хандлагаас үүдэлтэй нийгмийн сөрөг үр дагаврыг онцолсон.

Сурагчдын үзэж буйгаар шударга ёс нь зөвхөн хууль тогтоогч, хууль сахиулагч нарт хамааралтай ойлголт биш, харин хүн бүрийн зан үйл, ёс суртахуунтай шууд холбоотойг харуулж байна. Худал хэлэхгүй байх, үнэнч байх, хариуцлагатай байх, тэгш хандах зэрэг нь шударга ёсны үндсэн шинжүүд гэж нийтлэг тодорхойлсон байна.


### 3.3. Эцэг, эхчүүдийн судалгааны дүн

Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ шударга байдлын талаар ярилцдаг эсэхийг хүйсээр авч үзэхэд ээж нарын 56 хувь нь байнга, 43.1 хувь нь заримдаа ярилцдаг гэсэн бол 0.9 хувь нь огт ярилцдаггүй байна. Харин аав нарын 47.4 хувь нь байнга, 50.9 хувь нь заримдаа ярилцдаг бол 1.7 хувь нь хүүхэдтэйгээ шударга байдлын талаар огт ярилцдаггүй байна. Судалгаанаас харахад хүүхэдтэйгээ шударга байдлын талаар ярилцдаг эцэг эхчүүдийн тоо өмнөх онуудаас тогтмол ихсэж буй нь сайн үзүүлэлт юм. Мөн түүнчлэн гэр бүл нь хүүхдийн нийгэмшлийн анхдагч орчин болохын сацуу гэр бүлийн хүрээнд олж авсан мэдээ, мэдээлэл нь хүүхдэд чухал нөлөөтэй байдаг. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхэдтэйгээ зөв буруу, сайн муу, шударга, шударга бусын талаар нээлттэй ярилцаж, ойлгуулж байх хэрэгтэй.

Зураг 22. Та хүүхэдтэйгээ шударга байдлын талаар ярилцдаг уу?



Зураг 23. Та хүүхдээ буруу зүйл, шударга бус зүйл хийснийг мэдвэл хэлж, ойлгуулдаг уу?



Судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүдээс хүүхдийг шударга хүн болгож төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаарх саналыг авч дараах байдлаар нэгтгэв.

- Шударга байдлын үлгэр дуурайлал үзүүлэх:**
  - Хүүхдүүд гэр бүлийн орчинд эцэг, эхийн шударга байдлыг харж суралцдаг.
  - Шударга шийдвэр гаргаж, үг, үйлдэлдээ тууштай байх нь чухал.
- Эцэг, эхчүүдийн харилцаа, ойлголцол:**
  - Хүүхдүүдтэйгээ илэн далангүй ярилцаж, шударга байхын ач холбогдлыг тайлбарлах.
  - Шударга бус үйлдлийн үр дагаврыг ойлгуулах, таниулах.
- Хүүхдэд хариуцлага, итгэл хүлээлгэх:**
  - Өөрийн үйлдэлд хариуцлага хүлээж сургах.
  - Хийсэн үйлдлийнхээ сайн, муу талыг ойлгож, дүгнэлт хийх чадварыг хөгжүүлэх.
- Боловсрол, ёс зүйн хичээл:**
  - Сургууль, гэр бүлийн хамтын ажиллагаагаар шударга байдлын талаар системтэй сургалт явуулах.
  - Ёс зүй, хүний эрхийн талаар ойлголт өгөх.
- Нийгмийн орчин:**
  - Хүүхдийг шударга орчинд өсгөх, шударга бус нөхцөл байдал үүсэхэд хэрхэн хариу үйлдэл хийхийг зааж сургах.

- Найз нөхдийн зөв хүрээлэл бүрдүүлэхэд анхаарах.

**6. Хувь хүний хөгжил:**


- Хүүхдэд өөрийн үйлдлийн сайн, муу талыг ойлгуулж, хариуцлага хүлээж сурах боломж олгох.
- Хүүхдэд шийдвэр гаргалтад оролцох боломжийг олгож, туршлага хуримтлуулахад дэмжлэг үзүүлэх.
- Хүүхдийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх.

Эцэг, эхийн болон сургуулийн хамтын ажиллагаа, нийгмийн дэмжлэгийг нэгтгэн хэрэгжүүлснээр хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх үйл явцыг үр дүнтэй болгох боломжтой.

### 3.4 Багш, албан хаагчдын судалгааны дүн

Судалгаанд оролцсон багш, албан хаагчдын 95.2 хувь нь сургуулийн албан хаагчид сурагчдад зөв шударга хүн болж төлөвшихөд үлгэр дуурайл болдог гэж үзсэн бол багш, албан хаагчдын 4.8 хувь нь сургуулийн албан хаагчид хүүхдийн төлөвшилд үлгэр дуурайл болдоггүй гэж үзсэн байна. Мөн 99.8 хувь нь хүүхдийн шударга, зөв төлөвшилд гэр бүлийн орчин чухал гэж үзжээ.

Багш нараас авсан судалгааны дүнгээс үзэхэд нийт багш нарын 84% нь ЕБС-ийн хичээлийн хөтөлбөр хүүхдэд зөв, шударга хүн болж төлөвших дадлыг олгож чаддаг гэж үзсэн бол 16% нь **чаддаггүй** гэж үзсэн байна. **Шалтгааныг тодруулбал:**



#### 1. Багшийн ур чадвар, бэлтгэл хангалтгүй байх:

Зарим багш нар хөтөлбөрт тусгасан шинэ арга зүй, сургалтын агуулгыг бүрэн ойлгож, хэрэгжүүлж чаддаггүй.

**2. Нөөцийн хязгаарлалт:** Сургалтын материалаар хангагдаагүй, сургуулийн техник хэрэгсэл дутмаг байдал. Хөтөлбөрт тусгасан зарим үйл ажиллагаа (жишээ нь, судалгаа, практик туршилт) нь шаардлагатай техник хэрэгслийг ашиглах боломжгүй байх.

**3. Эцэг эхийн дэмжлэг сул байх:** Хүүхдийг сургуулиас хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээнд оролцуулахад эцэг эхийн зүгээс дэмжлэг үзүүлэхгүй байх.

**4. Хүүхдийн идэвх, оролцоо дутмаг:** Хэт их онолын агуулга, практик дасгал дутмаг байдал. Хөтөлбөрийн агуулга, аргачлал нь хүүхдийн сонирхлыг татахгүй байх.

**5. Хөтөлбөрийн уялдаа сул байх:** Хичээлүүд хоорондын уялдаа холбоо дутмаг, сургалтын зорилт тодорхойгүй байх. Ёс суртахуун, шударга ёсыг ойлгохыг нэг хичээлд онцлоод, бусад хичээлүүдэд орхигдуулах. Хүүхдийг залхаах шинжтэйгээс гадна бодит амьдралтай огт холбогддоггүй.

**6. Нийгмийн нөхцөл байдлын нөлөө:** Хүүхдүүдийн өдөр тутмын амьдралд шударга ёсны жишээнүүд хангалтгүй байх, эсвэл эсрэгээр шударга бус байдлыг харах нь хөтөлбөрийн үр нөлөөг сулруулах.

Багш нараас авсан судалгааны дүнгээс үзэхэд нийт багш нарын 84% нь ЕБС-ийн хичээлийн хөтөлбөр хүүхдэд зөв, шударга хүн болж төлөвших дадлыг олгож **чаддаг** гэж үзсэн **шалтгааныг тодруулбал:**

Хичээлийн хөтөлбөр нь хүүхдийн зан чанар, нийгмийн ухамсрыг төлөвшүүлэхийг зорьдог. Тухайлбал, шударга ёс, эрх тэгш байдлын тухай ойлголтыг өсвөр насныханд таниулж, хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэсэн байдаг. Дараах хичээлүүдийн хөтөлбөр, агуулга хэрхэн хүүхдэд эергээр нөлөөлдөг талаар дурдсан байна.

1. Иргэний ёс зүй, Түүх, Нийгмийн хичээлийн агуулгаар тохиолдол задлан шинжилж, бусадтай эрх тэгш, хүнлэг энэрэнгүй байх талаар мэдлэг олгодог.
2. Монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлээр заадаг эх зохиол дандаа сургамжит санаа агуулсан байдаг.
3. “Математик” бол худал хэлж болохгүй ухаанд сургадаг. Тэнцүү бол тэнцүү үгүй бол худал бичихгүй.
4. Монгол ёс, хүмүүжил хичээл дээр зөв хандлага төлөвшлийн хичээлүүд ордог.
5. Спортоор хичээллэж байгаа сурагчдын харилцаа хандлага сайн байдаг.

6. Хичээл бүрийн хөтөлбөрт хүүхдийг зөв, шударга хүмүүжүүлэх хүмүүжлийн арга хэлбэрүүд байдаг.

Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад дараах бэрхшээлүүд нийтлэг тулгарч байна гэж үзжээ:

**1. Эцэг эхчүүдийн оролцоо сул байх:** Хүүхдийн боловсролд анхаарал хандуулах цаг зав дутмаг, эсвэл сургалтын үйл явцыг ойлгохгүй байх. Зарим эцэг эхчүүд хичээлийн хөтөлбөрийн агуулгыг мэдэхгүй, хүүхдийн дэвтэр, гэрийн даалгаврыг шалгахгүй орхигдуулдаг.

**2. Ёс суртахууны хандлага дутмаг:** Эцэг эхчүүд өөрсдөө шударга бус үйлдлийг хэвшүүлсэн байх нь хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг. Гэртээ шударга бус шийдвэр гаргах эсвэл ёс зүйгүй үйлдэл хийж дадсан хүүхэд сургууль дээр ирээд бусдадаа муугаар нөлөөлдөг.

**3. Хүүхдийн боловсролд ач холбогдол өгөхгүй байх:** Зарим эцэг эхчүүд боловсролын ач холбогдлыг дутуу үнэлж, сургуулийн үйл ажиллагаанд оролцохоос татгалздаг. Хүүхдийн гэрийн даалгаварт хяналт тавихгүй байх эсвэл хичээлд ирцэд анхаарахгүй байх.

Эцэг эхчүүдийн дэмжлэг нь хүүхдийн хүмүүжилд чухал үүрэгтэй бөгөөд дээрх алдаа дутагдлыг засан сайжруулж хичээлийн хөтөлбөрийн үр нөлөө нэмэгдэх боломжтой.

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Хүүхдийн шударга байдлын түвшин болон түүний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдал ямар түвшинд байгааг тодорхойлох, цаашид хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, шударга бус хандлагаас нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоох зорилгоор “Хүүхдийн шударга байдал-2024” судалгааг зохион байгууллаа. Судалгааны мэдээллийг цахим хэлбэрээр “SurveyMonkey” судалгааны программыг ашиглан, 21 аймаг, нийслэлийн төрийн өмчийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулиудын 10-12 дугаар ангийн сурагчдыг хамруулан явуулав. Энэ удаагийн судалгааны дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Хүүхдийн шударга байдлын түвшин 2024 онд 4.05 оноотой гарч өмнөх буюу 2023 оноос 0.08 оноогоор өссөн дүнтэй байна. Судалгаанаас үзвэл хүүхдийн шударга байдлын үндсэн үзүүлэлтэд томоохон өөрчлөлт гараагүй байгаа ч эерэг тал руу тэмүүлэх хандлага ажиглагдаж байна.
- Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 4.17, зан төлөвшлийн дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 4.37, хууль сахих байдлын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.81, авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 3.83 байна.
- Хүүхдийн шударга байдлын түвшний үзүүлэлтийг оршин суугаа нутаг дэвсгэрээр харьцуулан үзвэл жил Дундговь аймгийн хүүхдийн шударга байдал 4.33 буюу хамгийн өндөр үнэлгээтэй байна. Харин Орхон аймгийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин 3.84 буюу хамгийн бага дүнтэй гарчээ.
- Нийт судалгаанд хамрагдсан 21 аймгаас 9 аймгийн хүүхдийн шударга байдлын түвшин улсын дунджаас өндөр дүнтэй гарч, Баянхонгор болон Булган аймгийн хүүхдийн шударга байдлыг түвшин улсын дундажтай тэнцүү үнэлэгдэв. 10 аймгийн үзүүлэлт улсын дунджаас доогуур дүнтэй гарчээ. Өмнөх жилийн судалгааны үзүүлэлтээр Орхон аймаг хүүхдийн шударга байдлын түвшнээр мөн адил хамгийн бага үнэлэгдэж байсан ба тус үзүүлэлт давтагдлаа.
- Хамгийн өндрөөр үнэлэгдсэн Дундговь аймаг болон хамгийн багаар үнэлэгдсэн Орхон аймгуудын хүүхдийн шударга байдлын түвшний зөрүү 0.49 байгаа нь анхаарал татахуйц хол зөрүүтэй байна.
- Хүүхдийн шударга байдлын түвшинг Нийслэлийн дүүргүүдээр харьцуулан үзвэл Сонгинохайрхан дүүрэг 4.25 буюу улсын дунджаас 0.2 оноогоор өндөр үзүүлэлттэй гарсан байна. Харин Багахангай дүүргийн хүүхдийн шударга байдлын түвшин хамгийн бага буюу 3.80 оноотой гарч, хоорондоо 0.45 онооны зөрүүтэй байна.
- Сонгинохайрхан, Багануур дүүргүүдийн хүүхдийн шударга байдлын түвшин улсын дунджаас өндөр гарсан бол Чингэлтэй дүүргийн хүүхдийн шударга байдлын түвшин улсын дундажтай тэнцүү, Налайх, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Баянгол, Багахангай дүүргүүдийн хүүхдийн шударга байдлын түвшин улсын дунджаас доогуур үнэлгээтэй байна.
- Эмэгтэй хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.14 оноотой байгаа бол эрэгтэй хүүхдийнх 3.90 оноотой гарсан нь өмнөх онтой харьцуулбал өсөлттэй үзүүлэлт байна.
- Төрийн өмчийн сургуулиудын хүүхдүүдийн шударга байдлын түвшин 2024 онд 3.78 оноотой гарсан бол хувийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.08 буюу 0.3 оноогоор дээгүүр үзүүлэлттэй байна. Өмнөх онуудад төрийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшний үнэлгээ хувийн хэвшлийн

сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин үнэлгээнээс их гарч байсан бол, 2023 болон 2024 онд төрийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн үнэлгээ хувийн өмчийн сургуулийн хүүхдийн үнэлгээнээс бага гарсан байна. Энэ оны хувьд төрийн болон хувийн хэвшлийн сургууль хоорондын хүүхдийн шударга байдлын үнэлгээний зөрүү хамгийн өндөр гарч буй жилүүдийн нэг болж байна.

- Судалгаагаар шударга байх талаар гэрийнхэнтэйгээ байнга ярилцдаг хүүхдийн шударга байдлын түвшин 3.99 оноотой байгаа бол заримдаа ярилцдаг хүүхдийнх 4.21 оноотой, хэзээ ч ярилцдаггүй хүүхдийнх 3.62 оноогоор үнэлэгдсэн байна.
- Хүүхдийн шударга байдлын түвшинд эергээр нөлөөлөх нэг чухал хүчин зүйл бол тухайн хүүхдийг шударга хандсаных нь төлөө магтаж, сайшаадаг хүүхдийн шударга байдлын түвшин 3.96 оноотой, шударга байсан ч үл ойшоогддог хүүхдийн шударга байдлын түвшин 3.84 оноогоор үнэлэгджээ. Хүүхдийг шударга үйлдэл хийх, аливаа зүйлд шударга хандахад нь магтан сайшаах, урамшуулах нь хүүхдэд багаас нь аливаа зүйлд шударга, зөв байхыг төлөвшүүлэх эерэг нөлөөтэй гэж судалгааны мэдээллээс дүгнэж байна.
- Судалгаагаар шударга бус зүйл хийснийх нь төлөө гэр бүлийнхэн нь хэлж ойлгуулдаг хүүхдийн шударга байдлын түвшин 3.97 оноотой, зэмлэж шийтгэдэг бол 3.89 оноотой, гэр бүлийнхэн нь сонирхдоггүй бол 3.52 оноогоор үнэлэгджээ.
- Судалгаагаар шударга бус үйлдлийн талаар ангийнхан, найз нартайгаа ярилцдаг хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ 3.95 оноотой гарсан бол, ярилцдаггүй хүүхдүүдийн үнэлгээ 3.79 оноотой гарсан байна.
- Хичээлийн хөтөлбөрт нь шударга ёсны талаар агуулгыг багтаасан, шударга ёсны талаар хичээлээрээ дамжуулж мэдлэг, ойлголт авдаг хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.11 буюу шударга ёсны талаар хичээл заалгадаггүй хүүхдүүдийн шударга байдлын түвшнээс даруй 0.22 оноогоор их байна.
- Сургуулийн орчинд шударга ёсны талаар мэдээлэл авдаг хүүхдийн шударга байдлын түвшин хамгийн өндөр буюу 4.16 оноотой, удаагаар гэр бүлийнхээ орчноос шударга ёсны талаар мэдээлэл авдаг хүүхдийнх 4.11 оноотой, интернет орчноос мэдээлэл авдаг хүүхдийнх 3.87 оноотой, ном, хэвлэлээс мэдээлэл авдаг бол 3.99, телевиз, радиогоос мэдээлэл авдаг бол 3.97 оноотой, бусад эх сурвалжаас мэдээлэл авдаг бол 3.92 оноотой харин найз нөхдөөсөө мэдээлэл авдаг бол 3.85 оноотой гарчээ.
- Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга ёсны хандлага, төлөвшилд сургууль чухал эх сурвалж болохоос гадна тус орчинд мэдлэг, мэдээлэл авсан хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ хамгийн өндөр үзүүлэлттэй байна.
- Сурагчдын үзэж буйгаар шударга ёс нь зөвхөн хууль тогтоогч, хууль сахиулагч нарт хамааралтай ойлголт биш, харин хүн бүрийн зан үйл, ёс суртахуунтай шууд холбоотойг харуулж байна. Худал хэлэхгүй байх, үнэнч байх, хариуцлагатай байх, тэгш хандах зэрэг нь шударга ёсны үндсэн шинжүүд гэж нийтлэг тодорхойлсон байна.
- Судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүдээс хүүхдийг шударга хүн болгож төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаарх саналыг авахад үлгэр дуурайлал үзүүлэх, эцэг, эхчүүдийн харилцаа, ойлголцол, хүүхдэд хариуцлага, итгэл хүлээлгэх, боловсрол, ёс зүйн хичээл, нийгмийн орчин, хувь хүний хөгжил зэрэгт анхаарах нь хүүхдийг шударга хүн болон хүмүүжихэд хувь нэмэртэй гэж үзжээ.
- Судалгаанд оролцсон багш, албан хаагчдын 95.2 хувь нь сургуулийн албан хаагчид сурагчдад зөв шударга хүн болж төлөвшихөд үлгэр дуурайл болдог гэж үзсэн бол багш, албан хаагчдын 4.8 хувь нь сургуулийн албан хаагчид хүүхдийн төлөвшилд үлгэр дуурайл болдоггүй гэж үзсэн байна. Мөн 99.8% нь хүүхдийн шударга, зөв төлөвшилд гэр бүлийн орчин чухал гэж үзжээ.

- ЕБС-ийн хичээлийн хөтөлбөр хүүхдэд зөв, шударга хүн болж төлөвших дадлыг олгож чаддаг гэж багш нарын 84% үзжээ. Хичээлийн хөтөлбөр нь хүүхдийн зан чанар, нийгмийн ухамсрыг төлөвшүүлэхийг зорьдог. Тухайлбал, Иргэний ёс зүй, Түүх, Нийгмийн хичээлийн агуулгаар тохиолдол задлан шинжилж бусадтай эрх тэгш, хүнлэг энэрэнгүй байх талаар мэдлэг шударга ёс, эрх тэгш байдлын тухай ойлголтыг өсвөр насныханд таниулж, хүлээн зөвшөөрүүлэхэд анхаардаг гэж үзсэн байна.
- Хичээлийн хөтөлбөр нь хэтэрхий агуулга ихтэй, сурагчдад бодит ойлголт өгөхөөс илүү онолын талдаа төвлөрсөн. Хичээлийн хугацаа (40 минут) нь агуулгыг бүрэн заахад хангалтгүй. Мөн сургалтын хөтөлбөрийг 4-5 жилийн хугацаанд тогтмол шинэчилдэг, энэ нь сурагчдад болон багш нарт тодорхой бус байдлыг үүсгэдэг зэрэг шалтгааны улмаас ЕБС-ийн хичээлийн хөтөлбөр хүүхдэд зөв, шударга хүн болж төлөвших дадлыг олгож төдийлөн олгож чадахгүй байна гэж үзжээ.



**ТАВ. ЗӨВЛӨМЖ****БОЛОВСРОЛЫН ЯАМ:**

- Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлтүүдийн нэг болох хууль сахих байдлын дэд үзүүлэлт бусад дэд үзүүлэлтүүдээс бага гарсан буюу хүүхдийн хууль тогтоомж сахин биелүүлэх байдал, өөрийгөө хянаж нийгмийн тогтсон эрх зүйн хэм хэмжээг сахих чадвар сул байгааг илтгэнэ. Иймд тэдний насны онцлогт тохирсон эрх зүйн хэм хэмжээг таниулах үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай.
- Төрийн өмчийн сургууль болон хувийн өмчийн сургуулийн хүүхдүүдийн шударга байдлын түвшний зөрүүг арилгах. Төрийн өмчийн сургуулиудад хувийн өмчийн сургуулийн сайн туршлагыг нэвтрүүлэх.
- Багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулах, хэрэгжүүлэх.
- Сургалтын хөтөлбөр нь онолын мэдлэг дээр тулгуурласан, бодит амьдралд хэрхэн хэрэгжүүлэхийг төдийлөн зааж чадахгүй байна, иймд практикт суурилсан хөтөлбөрийг нэмэгдүүлэх шаардлагатай.
- Эцэг эхчүүдэд зориулсан шударга ёс, ёс зүйн талаар уулзалт, сургалтууд зохион байгуулж, тэдний оролцоог нэмэгдүүлэх.
- Хэдий сургуулийн орчинд багш болон албан хаагчид сургалтын хөтөлбөрийн дагуу хүүхдэд мэдлэг, боловсрол олгохоор хичээн ажиллаж байгаа ч эцэг эхчүүдийн дэмжлэг нь хүүхдийн хүмүүжилд чухал үүрэгтэй бөгөөд сургууль болон багш, эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг дэмжих.
- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлүүдийн уялдаа холбоог сайжруулж, хөтөлбөрийг орчин үеийн хүүхдүүдэд зориулж бэлтгэх. Зөвхөн мэдлэгтэй болоход бус зөв хүн болоход анхаарах.
- Хэт богино хугацаанд их агуулга багтаах гэж оролдох нь сурагчдад гүнзгий ойлголт өгөх боломжийг хаадаг тул хичээлийн агуулга болон цагийг уялдуулан тохируулах.

**ОЛОН НИЙТ:**

- Хүүхдийн шударга байдлын түвшинд эергээр нөлөөлөх нэг чухал хүчин зүйл бол тухайн хүүхдийг шударга хандсаныг нь төлөө магтаж сайшаах, урамшуулах, шударга бус зүйл хийснийг нь төлөө хэлж ойлгуулах, тухайн нөхцөл байдалд тохирсон зохих хариу арга хэмжээг авч байх.
- Эцэг эхчүүд өөрсдөө шударга бус үйлдлийг хэвшүүлсэн байх нь хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг. Гэртээ шударга бус шийдвэр гаргах эсвэл ёс зүйн ухамсаргүй үйлдэл үзүүлэхгүй байж зөв үлгэр дуурайл үзүүлэх.
- Эцэг эхчүүдийн дэмжлэг нь хүүхдийн хүмүүжилд чухал үүрэгтэй бөгөөд сургууль болон багш нартай нягт хамтран ажиллаж хичээлийн хөтөлбөрийн үр дүнг нэмэгдүүлэх.

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР:**

- Нийгмийн орчинд шударга ёсны талаар мэдээлэл, соёл түгээх ажлыг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан зохион байгуулах.

**ЗУРГАА. ХАВСРАЛТ**

Хавсралт 1. Хүүхдийн шударга байдлын түвшин, дэд үзүүлэлтээр

<b>Хүүхдийн шударга байдал - 2024 он</b>			
Дундаж үнэлгээ	Үзүүлэлт		Үнэлгээ
<b>А. Ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт</b>			
4.17	Танин мэдэхүйн	Хүүхдүүд интернэтэд байгаа бусдын бүтээлээс хуулбарлаж гэрийн даалгавраа хийхдээ эх сурвалжийг нь заавал дурдах албагүй.	3.73
	Нөлөөллийн	Баян байх нь шударга байхаас илүү чухал.	4.27
	Зан үйлийн	Кино үзэхийн тулд урт дараалалд зогссоноос урдуур нь дайрч хурдан кинондоо орно.	4.52
<b>Б. Зөв төлөвшилтийн дэд үзүүлэлт</b>			
4.37	Танин мэдэхүйн	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь байж болох зүйл.	4.51
	Нөлөөллийн	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.	4.54
	Зан үйлийн	Гэмт хэрэг үйлдсэн, авлига, хээл хахууль авсан хэн нэгнийг би зохих байгууллагад нь мэдэгдэнэ.	4.07
<b>В. Хууль сахиx байдлын дэд үзүүлэлт</b>			
3.81	Танин мэдэхүйн	Дотнын найз минь шалгалт өгч байхдаа бусдаас хуулж байвал би “найз минь юм чинь за яах вэ дээ” гэж бодно.	3.22
	Нөлөөллийн	Төрийн албан хаагч төрийн үйлчилгээ үзүүлснийхээ төлөө шан харамж авч болно	4.14
	Зан үйлийн	Гэмт хэрэг үйлдсэн, авлига, хээл хахууль авсан хэн нэгнийг би зохих байгууллагад нь мэдэгдэнэ.	4.07
<b>Г. Авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлт</b>			
3.83	Танин мэдэхүйн	Том хүмүүсийн үйлдэл хууль бус байсан ч надад ашигтай байвал хүлээн зөвшөөрнө.	4.09
	Нөлөөллийн	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь миний сайн найз байсан ч би өөрийн итгэдэг багш, эцэг, эх, хэн нэгэнд мэдэгдэнэ.	3.08
	Зан үйлийн	Манай гэр бүл баяжиж л байвал миний аав, ээж эрх мэдлээ ашиглах, хууль зөрчих нь надад хамаагүй.	4.33
<b>Хүүхдийн шударга байдлын үнэлгээ</b>			<b>4.05</b>

Хавсралт 2. Хүүхдийн шударга байдлын түвшин, аймгаар

д/д	Аймаг, нийслэл	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	Зөрүү
1	Архангай	3.99	4.05	4.00	3.90	4.03	0.13
2	Баян-Өлгий	3.80	3.51	3.66	4.19	3.89	-0.30
3	Баянхонгор	4.04	4.10	4.05	3.86	4.05	0.20
4	Булган	3.92	4.00	4.00	4.00	4.05	0.04
5	Говь-Алтай	3.89	4.08	4.01	4.09	4.17	0.09
6	Говьсүмбэр	4.04	4.09	3.87	3.98	3.95	-0.03
7	Дархан-Уул	4.03	4.04	3.96	3.88	4.01	0.14
8	Дорноговь	4.08	4.03	3.89	4.00	4.03	0.02
9	Дорнод	4.02	4.10	4.03	4.11	4.14	0.04
10	Дундговь	4.07	4.13	4.14	4.18	4.33	0.15
11	Завхан	3.97	4.09	4.01	3.97	4.06	0.09
12	Орхон	4.06	4.02	3.97	3.79	3.84	0.05
13	Өвөрхангай	4.05	4.01	4.06	4.03	4.14	0.10
14	Өмнөговь	4.03	4.17	4.01	4.06	4.02	-0.04
15	Сүхбаатар	4.08	4.10	4.00	4.00	4.20	0.20
16	Сэлэнгэ	4.01	4.08	3.90	3.95	4.11	0.16
17	Төв	3.95	4.14	3.99	3.98	4.00	0.02
18	Увс	4.09	4.17	4.05	4.06	4.29	0.23
19	Ховд	3.98	4.03	3.96	3.99	4.04	0.05
20	Хөвсгөл	4.07	4.07	4.04	4.01	4.19	0.18
21	Хэнтий	3.95	4.05	3.98	3.89	4.01	0.12
22	Улаанбаатар	4.03	4.09	3.92	3.92	3.98	0.06

Хавсралт 3. Хүүхдийн шударга байдлын түвшин, дүүргээр

д/д	Дүүрэг	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	Зөрүү
1	Баянзүрх дүүрэг	4.01	4.11	3.87	3.81	3.94	0.13
2	Баянгол дүүрэг	4.12	4.09	3.93	3.90	3.85	-0.04
3	Багануур дүүрэг	4.08	4.11	4.14	4.02	4.19	0.17
4	Баганхангай дүүрэг	3.71	4.26	3.82	4.16	3.80	-0.36
5	Налайх дүүрэг	4.12	4.06	4.01	4.00	3.94	-0.05
6	Сүхбаатар дүүрэг	4.13	4.06	3.87	3.69	3.90	0.21
7	Хан-Уул дүүрэг	4.00	4.05	3.98	3.79	3.87	0.08
8	Чингэлтэй дүүрэг	4.13	4.05	3.78	3.85	4.05	0.20
9	Сонгинохайрхан дүүрэг	3.97	4.06	3.90	4.08	4.25	0.17